



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/388

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Гончигдорж овогтой Мөнгөнцогт (РЭ84012711)-ын Мөрөн сум 5 дугаар баг Олонд туслах эмнэлгийн зүүн талд байршилтай 6712008043 нэгж талбарын дугаартай 203м² худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлсэн газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан тул өөрийнх нь хүсэлтийн дагуу 30 жилийн хугацаагаар сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/249 дүгээр захирамжийн хавсралтын 8 дахь заалтын 8 дахь баганыг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч иргэн Г.Мөнгөнцогттой газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

